ВИДЕО ШТОРК · 2024 оны 4-р сарын 26

2024 ОНЫ I УЛИРАЛ- ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ХЭРГИЙН 67.5 ХУВЬ НЬ ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ, МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГ БАЙНА



2024 оны I улиралд байгаль орчинд хохирол учруулсан 373 хэрэгт прокурор хяналт тавьж, 155 хүн, 5 хуулийн этгээдэд холбогдох 99 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Энэ төрлийн хэргийн 67.5 хувийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын зүгээс ойн модыг зөвшөөрөлгүйгээр бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээгүйгээр тээвэрлэх, худалдан борлуулах, мөн тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал хайх, олборлох зэргээр байгаль орчинд хохирол учруулсан гэмт хэрэг эзэлж байна. Тодруулбал,

- Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 128,

- Хууль бусаар мод бэлтгэх 124,

- Хууль бусаар ан агнах 54,

- Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх 32,

- Химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах 26,

- Ой, хээрийн түймэр тавих 6 хэргийг шүүхээр шийдвэрлүүлжээ.

Мөн прокурорын зөвшөөрлөөр гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгсэл, хууль бусаар олсон байгалийн баялаг, амьтан, ургамал, түүхий эд зэргийг хураан авах, битүүмжлэх ажиллагааг явуулж, нийт 445.6 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг улсын орлого болгуулсан байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн 53 орчим хувь нь Сэлэнгэ, Төв, Булган, Хөвсгөл аймагт бүртгэгдсэн бөгөөд 2023 оны мөн үеэс 25.5 хувиар буурчээ.

Видео: https://www.youtube.com/watch?v=7tD4GtZcVL8

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1154